

“ЧИНГИС ХААНЫ НАМТАР” НОМЫН ТУХАЙ

Д.Сүхбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

2004 онд Бээжин хотноо зохиогч Зү Ёо Тин-ийн “Чингис хааны намтар” ном Ардын хэвлэлийн хороонд 5000 хувиар хэвлэгдэж уншигчдын анхаарлыг ихээр татжээ. Уг бүтээл нь хаадын намтрын цувралд багтан Хубилай хааны дараа аравдугаарт хэвлэгдсэн байна.

Зохиогч Зү Ёо Тин нь Бээжингийн Их сургуулийн түүхийн салбарыг төгсөж, “Хятадын соёлын хувьсгал”-ын дараа тус сургуульд багшилсан. Тэрбээр оюутан байхаасаа Монголын түүх, Чингис хааны намтрыг ихэд сонирхож байсан бөгөөд түүний бүтээлүүд 2000 оноос хойш олны анхаарлыг татах болжээ. Зү Ёо Тин 2001 онд Чингис хааны тухай түүхэн роман болон баримтат кино зохиол, “Чингис хааны бүрэн намтар” номыг тус тус бичиж туурвижээ. Түүний бичсэн Чингис хааны тухай түүхэн роман нь 2001 онд Бээжин хотын шилдэг номоор шагнагдсан байна. Тэрээр өмнөх бүтээл, судалгааны ажилдаа түшиглэж “Чингис хааны намтар” хэмээх уг бүтээлийг туурвижээ. Тус бүтээлийг туурвихдаа “Монголын нууц товчоо”, “Юань улсын түүх” болон Монголын түүхэнд холбогдох олон баримтуудыг ашигласан байна.

“Чингис хааны намтар” ном нь 8 бүлэг, 49 зүйлтэй. Эхний 7 бүлэгт Чингис хааны уг гарал, намтар түүхийг “Монголын нууц товчоо” зохиолд түшиглэн бичсэн байна. Харин 8-р бүлэг болох “Чингис хааныг хэрхэн ойлгох вэ?” хэмээх төгсгөлийн бүлэгтээ өөрийн үзэл санааг тусгайлан 4 зүйл болгон бичсэн байна.

Наймдугаар бүлэг нь хэдийгээр зохиогчийн үзэл санааг тусгасан боловч Чингис хааны тухай Хятадад хэвлэгдсэн сүүлчийн бүтээлүүдийн тоонд зүй ёсоор багтаж байгаа тул судлаач миний бие уг бүтээлийг бүхэлд нь шүүмжлэх бус зөвхөн 8-р бүлгийн 4 зүйлд анхаарлаа хандуулж өөрийн байр суурийг илэрхийлж байна.

“Чингис хааныг хэрхэн ойлгох вэ?” хэмээх 8-р бүлэг нь дараах 4 зүйлээс бүтжээ. Үүнд:

1. Дэлхийн алдартнууд Чингис хааныг хэрхэн мэддэг вэ?
2. Чингис хааны аян дайны амжилтын учир шалтгаан
3. Чингис хааны сод авъяас билэг, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлсэн нь
4. Монгол угсаатны гарал үүсэл, Чингис хааны харъяатын зарим асуудал зэрэг болно.

Чингис хааны аян дайны амжилт түүний авъяас билэг дэлхий нийтэд хэрхэн танигдсан тухай эхний гурван зүйлд тэмдэглэгдсэн боловч монгол угсаатны гарал үүсэл, Чингис хааны харъяатын зарим асуудал хэмээх 4-р зүйл нь монголын түүх, Чингис хааны угсаа гарлын талаар зохиогчийн үзэл санааг шууд илэрхийлсэн байна.

Чингис хааны харъяатын тухай өгүүлэхдээ тус номын 586-р талд “Чингис хаан монгол хүн үү, эсвэл хятад хүн үү?” хэмээх асуулт тавьж зохиогч өөрөө хариулт өгчээ. Тэрбээр “Чингис хаан бол хятад хүн мөн гэж би бодож байна. 1206 онд Чингис хаан Хятадын эзэмшил газар нутаг дотор улсаа байгуулсан. Тэгвэл Хятадын газар нутагт улс байгуулсан нь тусгаар улс мөн үү? хэмээгээд энэ асуудалд эрдэмтэд янз бүрээр тайлбар өгдөг гэхдээ түүхэн бодит хариултыг олох хэрэгтэй. Чингис хаан хятад хаан мөн, өөрөөр хэлбэл, Хятадын хил хязгаар дотор монгол угсаатныг нэгтгэсэн. Монгол угсаатан нь эртнээс хятадын олон үндэстэн угсаатны нэг бүрэлдэхүүнд багтдаг учраас энэ түүхэн бодит үнэнийг өөрчилж болохгүй. Хүннү нар Хятадын хойд зүгт амьдардаг байсан бөгөөд тэдний удам угсаа Эргүнэ гол руу нүүдэллэж олон зуун жил амьдарсан. Дараа нь Тан улсын түүхийн сурвалжид “Монгу-шивэй” нэрээр тэднийг нэрлэж

байсан нь Тан улсын бүрэлдэхүүнд багтаж байсны нотолгоо юм. Энэ нь Сяньби, Кидан нартай адилхан Дунху хүннүүд нэгэн угсаатан байсны илэрхийлэл юм. Түүнээс хойш тэд олон хэсэгт салж баруун болон өмнө зүг рүү нүүдэллэж, зарим нь монголын тал нутагт суурьших болсон. Тэр цаг үеэс монголын тал нутагт хүннү түрэг нарын өвөг дээдэс хамтран амьдрах болсв. Түүхээс үзвэл, Цэнь, Хан, Сүй, Тан, Сүн, Юань, Мин, Чин улсуудын захиргаанд монгол угсаатнууд нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байсан. Энэ нь түүхийн суурь ойлголт мөн" гэжээ.

Тэрбээр уг бүтээлийн 587- 588-р талд "Бидний мэддэг Чингис хаан өнөөгийн монголын тал нутагт төрсөн ч гэсэн түүнийг хятад мөн гэж үзэхгүй байж болохгүй. 1206 онд Их гүрэн байгуулж монголын тал нутагт Хархорин нэртэй нийслэл хотоо байгуулсан. Хувилай хааны үед Кайпин (өнөөгийн Өвөрмонголын өөртөө засах орны Шилийн гол аймгийн Шулуун хөх хэмээх газар)-д шилжүүлж дараа нь Яньжин (өнөөгийн Бээжин хот)-д нүүлгэсэн. Гэвч тэр үед Монгол улс Хятадын нэгэн бүрэлдэхүүн хэсэг байсан. Хүннү, Сяньби, Түрэг, Киданчууд мөн адил хятадын бүрэлдэхүүнд багтаж байв. 1279 онд Чингис хааны ач Хувилай хаан хятадыг бүхэлд нь эзэлсэн бөгөөд үүнийг хятадын түүхэнд 3 дахь нэгдэл гэж үздэг. Тийм учраас олон үндэстэн ястан угсаатнаас ямар ч хүн хаан ширээнд сууж болдог. Хувилай хаан бол хятадыг бүхэлд нь эзэмшсэн олон үндэстний хаан юм. Юань гүрний үед монголчууд бусад үндэстэн угсаатнаас дээд зэрэгт хүндлэгдэж байсан ч хятадын бүрэлдэхүүнд багтаж байв. Иймээс миний бодоход Чингис болон болон Хувилай хаад нь хятад үндэстний өвөг дээдэс мөн. Чингис хаан бол монгол угсаатан, хятад үндэстний баатар билээ. Тийм учраас Юань гүрэн мөхснөөс хойш тал нутагтаа нүүдэллэсэн монголчууд хойд Юань хэмээх нэрээр Мин улсын засаг захиргаанд багтаж байсан. Манж Чин улс байгуулагдсаны дараа ч монголын олон аймаг Ар Монгол ч түүний захиргаанд байлаа. 1921 оноос монголчууд олон оронд амьдарч байна. Өнөөгийн Монгол улс ба Хятадын нутаг дэвсгэр дээрхи Өвөрмонголын өөртөө засах орны монголчууд ч Чингис хааны үр сад гэдгийг бид зөвшөөрөх ёстой. Тэд нарын хувьд Чингис хаан нь цорын ганц өвөг дээдэс юм. Тиймээс Чингис хааныг ямагт хүндэлдэг түүнийг нь ч бид ойлгох ёстой. Гэвч монголчууд тус тусдаа салахын өмнө Ар Монгол, Өвөр Монгол, Шинжааны хил доторхи монголчууд нь хятад үндэстнүүдийн нэгэн байсан бөгөөд үндэстний асуудалд заавал түүхийг хүндэтгэн үзэх шаардлагатай. Монголчууд олон оронд саланги амьдарч байгаа ч, 1206 онд Чингис хаан Монголын их гүрэн байгуулсан нь ч хятад хүн биш гэх тайлбар хийж чадахгүй байна" хэмээжээ.

Дээрхээс үзвэл, нэгдүгээрт тус зүйлд зохиогчийн үзэл санаа хэт давамгайлж Чингис хааныг хятад хүн хэмээн томъёолсон, хоёрдугаарт хөрш улсын түүхэнд монголчуудын эзлэж байсан байр суурийг түүхэн үнэн зөвөөр дүгнэж чадаагүй, монголчуудын угсаа залгамжилсан Хувилай хааны төрийн бодлогыг Чингис хааны төрийн бодлогын үргэлжлэл тул Чингис болон Хувилай хааныг ч хятадын хаад хэмээн хэт нэг талыг барьсан дүгнэлт хийсэн. Гуравдугаарт, монголын эртний улсуудын түүх, соёл, нүүдэлчид болоод соёл иргэншлийн ялгаатай талыг түүхэн эх сурвалжид түшиглэж үнэн зөв тодорхойлолгүй нүүдэлчдийн соёл иргэншил бүхэлдээ үе үеийн хятадын төр улсын бүрэлдэхүүнд багтаж байгаа хэмээн эндүү ташаа илэрхийлжээ. Дөрөвдүгээрт, Манж Чин гүрний захиргаанд хятад, монгол бусад олон үндэстэн харъяалагдаж байсныг үндэслэн ХХ зуунаас олон салангид амьдарч буй монголчуудыг (Ар монгол, Өвөр монгол, Шинжааны монгол) хятадын үндэстний цөөнхид хамааруулсан нь түүхэн тодорхой бодит үнэнийг гуйвуулсан байна.